

**ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮГЧИЙН
ЗАХИРАМЖ, ШҮҮГЧИЙН ТОГТООЛЫГ ХЯНАХ АСУУДАЛ**
**ISSUES OF PROCEEDINGS OF JUDGE'S ORDERS AND DECISIONS
DUE TO NEWLY DISCOVERED CIRCUMSTANCES**

Д.Энх-Амар

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэний “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх”-ийг баталгаажуулсан байдаг төдийгүй хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн үндэслэлд ноцтой нөлөөлөхүйц баримт шинээр илэрсэн тохиолдолд хэргийн оролцогчийн хүсэлтээр хэргийг дахин хянан шийдвэрлүүлэх зохицуулалт ч хуульд бий.¹

Гэвч практикт шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн шийдвэрээс ангид ойлгогдох тохиолдлууд байгаа буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах “хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр”-т хамаарахгүй гэж шийдвэрлэж байгаа тохиолдол цөөнгүй байх бөгөөд энэ нь эрх зүйн зохицуулалт, онолын үзэл баримтлалд нийцэхгүй юм. Иймд тус өгүүллээр хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэгт юуг хамааруулан ойлгох талаар холбогдох эрх зүйн зохицуулалт, онолын үзэл баримтлалыг судалсан төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зарим шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах шүүхийн шийдвэрт хамааруулах нь зүйтэй эсэхийг тогтоох зорилгоор бичлээ.

Илтгэл нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэх бөгөөд үндсэн хэсэг нь 3 дэд хэсгээс бүрдэнэ.

Энэхүү илтгэлд дурдсан агуулга, үзэл санааг илтгэл бичигч нь хувь судлаачийн үүднээс хандаж бичсэн бөгөөд аливаа байгууллагын үзэл баримтлал, байр суурийг төлөөлөхгүй болно.

Түлхүүр үг: Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, шинээр илэрсэн нөхцөл байдал, шийдвэрийг дахин хянах

Удиртгал

¹ ЗХШХШТХ-ийн 14-р бүлэг

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ¹ (цаашид “ЗХШХШТХ” гэх)-ийн 14-р бүлгээр зохицуулсан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах зохицуулалт нь Үндсэн хуульд заасан иргэний “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх”-ийг баталгаажуулсан нэг хэлбэр мөн. Гэвч тус хуульд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай зохицуулалт байхгүй (хуулийн бичвэрт орхигдсон)-гээс үүдэж шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн шийдвэрээс ангид ойлгогдох тохиолдлууд гарч байна.

Угтаа шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь зарим тохиолдолд аливаа хэргийн хувьд эцсийн шийдвэр байх боломжтой байдаг бөгөөд ийнхүү шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах боломжгүй байх нь иргэний эрхийг дордуулж буй үзэгдэл болох юм. Иймд тус өгүүллээр шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил эрх зүйн чадамжтай эсэхийг тодруулах, цаашлаад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, түүнд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Үндсэн хэсэг

1.6 Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтын онцлог “... хүний үндсэн эрхүүд нь гагцхүү Үндсэн хуулийн шүүхээр бус харин захиргаанышүүхээр давхар хамгаалагддаг ... Учир нь эдгээр эрхүүд нь захиргааны өдөр тутмын үйл ажиллагаанд байнга өртөгдөж байдаг бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн процессоор хянагдаж, хамгаалагдаж байдаг. Иймд Үндсэн хуулийн эхний бүлэгт заасан хүний үндсэн эрхүүд нь захиргааны шүүхийн хувьд (мөн бусад шүүхийн хувьд ч ялгаагүй) шууд хэрэглэгдэх эрх буюу хэм хэмжээ болох бөгөөд энэ утгаараа захиргааны шүүх нь үндсэн эрхийг баталгаажуулах чухал үе шат юм.”²

Давж заалдах шатны шүүх гомдлын үндсэн дээр анхан шатны шүүхийн шийдвэрийгхянадаг нь шүүн таслах ажиллагаанд гарсан хууль хэрэглээний болон шийдвэрт нөлөөлөхүйц процессын шинжтэй аливаа алдааг залруулах буюу давтагдахаас сэргийлэх, оролцогчийн гомдлыг барагдуулах зэргээр хүний эрхийг хангах механизм шүүхэд хэрэгжиж байгаагийн илрэл юм. ³ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хэргийн оролцогчид хуульд заасан давж заалдах эрхээ баталгаатай эдлэх боломжийг хангах нь шүүхийн үүрэг билээ.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016) №09

² Г.Банзрагч, Герман-Монголын захиргааны процессын эрх зүйн харьцуулалт, (Улаанбаатар, 2007 он), 2 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=250>

³ З.Ганзориг, “Захиргааны хэргийн шүүхийн харъяаллын бус” үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авахаас татгалзахад тулгамдаж буй зарим асуудал, (Улаанбаатар, 2021 он), 1 дэх тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=971>

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар¹-т “давж заалдах гэдэг бол анхан шатны журмаар хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн тогтоол, шийдвэр, захирамжийг хуульд зааснаар эрх олгосон хугацаанд хоёрдугаар шатны шүүхэд гомдол мэдүүлэн заргалдах хугацаа юм” гэж тайлбарлажээ. Тодруулбал, давж заалдах эрхийн хүрээ нь зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолоор хязгаарлагдахгүй байгааг харж болно.

“Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг дахин хянуулах тухай хүсэлт бол эрх зүйн “онцгой” хэрэгсэл юм. Энэ хэрэгсэл нь нэгэнт явагдаад өнгөрсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг онцгой нөхцөл байдлын болон гэмт үйлдлийн улмаас дахин шинээр явуулан шударга ёсыг хангах, хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрийг гаргахад чиглэгддэг.”²

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах нь иргэний шүүхээр хамгаалуулах эрхээ бүрэн эдлэх, шүүхээс хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрийг гаргах эрх зүйн баталгаа болдог төдийгүй шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах нь шүүхийн шийдвэр, магадлал тогтоолыг хойшлуулах болон дээд шатанд нь шилжүүлэх үйлчлэлгүй. Энэ талаараа давж заалдах гомдол болон бусад гомдлоос ялгаатай. Тодруулбал, хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөлөөр хянуулах тухай хүсэлт нь шүүхийн шийдвэрт маргах хэрэгсэл биш, харин эрхийн хамгаалалтын онцгой хэрэгсэл юм.³

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтад холбогдох асуудал

Хэдийгээр хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэн ч биелүүлэх үүрэгтэй боловч шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчим зөрчигдсөний улмаас шүүхийн шийдвэр үндэслэлгүй буюу хууль бус гарсан байж болох “онцгой тохиолдол”-д хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг дахин хянах боломжийг хуулиар олгосон байна.⁴

“Захиргааны хэргийн шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтын онол, практикийн зарим асуудал” судалгааны тайлан⁵-д “Монгол Улсад захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлж буй шүүхүүдийн сүүлийн таван жилд (2017-2022 он) ЗХШХШТХ-ийн

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 2000 он, 123 дахь тал.

² А.Эрдэнэцогт, Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, УБ, 2014 он, 359 дэх тал

³ Э.Мөнхдаваа “Шинээр илэрсэн нөхцөлөөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл” (2022), 3 дахь тал. <https://legaldata.mn/b/1338>

⁴ Мөн тэнд

⁵ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн “Захиргааны хэргийн шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтын онол, практикийн зарим асуудал” (2022), 14 дэх тал. <https://legaldata.mn/b/1384>

131 дүгээр зүйлд зааснаар гаргасан 55 шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийсэн байна. Судалгаанд хамруулсан нийт 55 тогтоолын 16 буюу 29% нь хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулахаар хүсэлт гаргасан ба үүнээс 8 хүсэлтийг хангаж, 8 хүсэлтийг хангасан татгалзжээ” гэсэн дүгнэлтийг хийжээ.

ЗХШХШТХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэжээ. Уг зохицуулалтаас үзвэл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хамаарна. Харин хэргийг хянан шийдвэрлэх явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд хамаарахгүй байхаар ойлгогдож, мөн практикт хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй байдал үүсдэг, энэ дээрх судалгааны тайлангаар ч мөн тогтоогджээ. Угтаа ЗХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэлбэрүүдийг заасан байх ба үүнд шүүгчийн захирамжийг хамааруулан хуульчилсан байдгийг санах хэрэгтэй.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах нь зөвхөн захиргааны эрх зүйд хамаарах асуудал биш бөгөөд энэ талаар “ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гарсан гомдол нь тухайн шатны шүүх дээр шийдвэрлэгддэг. Зарим тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн дахин шүүхэд хандах эрхийг нэг мөр хязгаарласан ач холбогдол ихтэй гомдол энэ журмаар хэлэлцэгддэг. Тухайн шатны шүүх дотооддоо гомдол шийдвэрлэж байгаа нь хэргийн оролцогчдод шийдвэр нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхээс илүүтэйгээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрт давж заалдах эрхийг хязгаарлаж байна. Иймд давж заалдах шатны шүүхээр захирамж, тогтоолд гарсан гомдлыг хянан шийдвэрлэх нь иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах юм”¹ гэсэн байдаг.

Энэхүү эрх зүйн онцгой хэрэгслийг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд хэрэглэж болохооргүйгээр ЗХШХШТХ-д зохицуулсан нь сөрөг үр нөлөөтэй бөгөөд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт хамаарах үндэслэлтэй. Тодруулбал, Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох гэдэг нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

¹ Т.Бадрах “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” (2019), 2 дахь тал. <https://legaldata.mn/b/942>

а) Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч (түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч) гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргаагүйн улмаас шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

б) Хэргийн оролцогчоос давж заалдах гомдол гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүх гомдлын дагуу хэргийг хянан шийдвэрлэж, дараах байдлаар магадлал гаргасан:

- давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй буюу үндэслэлгүй бол гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн;

- анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан;

- анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн бөгөөд эдгээр магадлалд хяналтын журмаар гомдол гаргаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

в) Давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд уг гомдлыг хяналтын шатны шүүх хянаад:

- шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон,

- шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан,

- магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчилсөн тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

Хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шат шатны шүүхийн шийдвэрүүд нь дээрх байдлаар хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд үүнээс гадна ЗХШХШтХ-д шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх нөхцөлүүдийг мөн хуульчилсан байдаг. Тухайлбал, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол; нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийн тогтоол нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг гомдол гаргах эрхгүй, шүүхийн эцсийн шийдвэр болдог (ЗХШХШтХ-ийн 122 дугаар зүйлийн 122.7).

Түүнчлэн шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдлыг онолын үүднээс тайлбарлавал¹ шүүхийн шийдвэр нь формаль эрх зүй болон агуулгын хувьд хүчин төгөлдөр байх шаардлагатай. Формаль эрх зүйн хүчин төгөлдөр байдал нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй болох, тухайн шийдвэр эцсийн шийдвэр болж хүчин төгөлдөр болсон байхыг илэрхийлнэ. Харин агуулгын хүчин төгөлдөр байдал нь тухайн шийдвэрлэгдсэн хэрэг маргааны агуулга (нэхэмжлэлийн шаардлага)-аар дахин маргаан үүсгэх боломжгүй, тус агуулгын хувьд шүүхээр шийдвэрлэгдэж эцэслэгдсэн байхыг ойлгохоор байна. Энэ утгаараа хэргийг

¹ Б.Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (УБ. 2021), 191 дэх тал.

хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол; нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийн тогтоол нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах шийдвэрт хамаарахаар байгаа юм.

ЗХШХШТХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно”, ИХШХШТХ-ийн 179 дүгээр зүйлийн 179.1-д “Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэж шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэх шийдвэрийг тусгайлан дурджээ. Харин ЭХХШТХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д “Дараах нөхцөл байдал тогтоогдвол шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэж, урьд гарсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг сэргээн шалгаж болно” гэж заажээ.

Тодруулбал, дээрх процессын хуулиудад шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хамаарахгүй байхаар адил зохицуулсан. Гэвч зарим шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын хувьд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах үндэслэл илэрч болно. Тухайлбал, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргийн хувьд нэхэмжлэгчийн мэдээгүй, мэдэх боломжгүй байсан шинэ нөхцөл байдал илэрснээр нэхэмжлэлийг хүлээн авах нөхцөл бүрдсэн байх боломжтой. Мөн хэргийн оролцогчид эвлэрсний дараагаар тус нөхцөл байдлыг мэдэж байсан бол эвлэрэх шийдвэр гаргахгүй байх байсан нөхцөл шинээр илэрч болно. Товчхондоо, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоос онцлогтой юм.

Шүүх ЗХШХШТХ-ийн 66-68 дугаар зүйлд заасны дагуу бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй, шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ. Гэвч хэргийн оролцогчид эвлэрсний дараагаар тус нөхцөл байдлыг мэдэж байсан бол эвлэрэх шийдвэр гаргахгүй байх байсан нөхцөл шинээр илэрч болно.

Мөн ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гаргадаг. Энэхүү шүүгчийн

захирамжийг эс зөвшөөрсөн бол давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд давж заалдах шатны шүүхээс ЗХШХШТХ-ийн 122 дугаар зүйлийн 122.6-д заасан тогтоолуудын аль нэгийг гаргана. Хэрэв давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон тохиолдолд нэхэмжлэгч нь тус асуудлаар дахин шүүхэд хандах эрхгүй болно.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд дахин гомдол гаргах эрхгүй, эцсийн шийдвэр болохоор хуульд зохицуулсан. Энэ нь шүүгчийн бие даасан, хараат бус байдал, шүүхийн аливаа шийдвэрийн хүчин төгөлдөр байдал, шүүхийн ачаалал зэрэг эерэг нөлөөлөлтэй байхыг үгүйсгэхгүй. Гэвч хэргийн оролцогч, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэдийн хувьд гомдол гаргах эрхээ эдэлж чадахгүй нөхцөлд хүргэж болзошгүй юм.

Дээрх 2 тохиолдол нь нэхэмжлэгчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-д заасан "...эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах" эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд хүргэх юм. Тус шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй, энэ үйл баримтын талаар шүүхэд дахин маргаан үүсэх боломжгүй, шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгүүлдэг¹ шүүхийн эцсийн шийдвэр байдаг. Эдгээр байдлаар нь тус 2 тохиолдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой адилтган үзэх боломжгүй юм.

1994 оны ИХШХШТХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1-д "Энэ хуулийн 128 дугаар зүйлд заасны дагуу бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай гарсан буюу, эсхүл хэргийн байдал өөрчлөгдсөн бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчилж болно" гэж заасан байжээ.

Мөн Улсын дээд шүүхийн 1997 оны "Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай" 318 дугаар тогтоолд² "“шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж” гэдэгт анхан шатны шүүхээс

¹ Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шүүхийн тогтоол нь ЗХШХШТХ-ийн 122 дугаар зүйлийн 122.7-д заасны дагуу эцсийн шийдвэр байдгаараа мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-г хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй бөгөөд шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелүүлнэ гэж заасантай эрх зүйн үр дагаврын хувьд адил нөхцөл үүсгэнэ. Тодруулбал, ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.6-д нэхэмжлэлд заасан үйл баримт, захиргааны үйл ажиллагааны талаар ... хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол байгаа бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үр дагаврыг үүсгэнэ.

² УДШ-ийн 1997 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоол "Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

иргэний хэргийг хянан шийдвэрлээд Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан шийдвэрээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах болон шийдвэр биелүүлэхтэй холбогдуулан гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хамааруулан ойлгоно”; “хэргийн байдал өөрчлөгдөх” гэдэгт бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсны дараа хуулийн 188 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай адилтгах нөхцөл байдал шинээр илэрсэн, ... зэргийг хамааруулан ойлгох бөгөөд энэ үндэслэлээр хэргийн оролцогчдын гаргасан хүсэлтийг тухайн шүүх буюу шүүгч эсхүл тухайн шүүхийн өөр бүрэлдэхүүн буюу шүүгч тогтоол, захирамж гарган шүүхийн тогтоол, захирамжийг хүчингүй болгох буюу өөрчилж болно” гэж заасан байжээ. Өөрөөр хэлбэл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэх шүүхийн шийдвэрт ХХША-тай холбогдуулан гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хамааруулан ойлгодог байсан байна.

УДШ-ийн 2007 оны “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай” зөвлөмжид¹ “хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр” гэдэгт ... шүүхийн шийдвэрийн нэгэн адил хэрэгждэг хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж хамаарна” гэжээ.

Дээрх УДШ-ийн тайлбар, зөвлөмж болон 1994 оны ИХШХШТХ-ийн зохицуулалтаас үзвэл ЗХШХШТХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан “хуулийн хүчин төгөлдөр анхан шатны шүүхийн шийдвэр”-т шүүгчийн захирамжийг хамааруулж ойлгож байсан гэж дүгнэж болох юм.

ДҮГНЭЛТ

Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулаад багагүй хугацаа өнгөрч байгаа боловч захиргааны процессын эрх зүйн салбарт тулгамдсан асуудал цөөнгүй байна. Хэргийг хянан шийдвэрлээд гаргасан эцсийн шийдвэрийн тухайд тухайлсан асуудлыг энэ өгүүллээр хөндөөгүй. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шийдвэр буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой холбоотой эргэлзээ бүхий асуудлуудыг тодруулан авч үзсэн болно.

Үндсэн хуульд заасан иргэний давж заалдах гомдол гаргах эрхийг хуулиар баталгаажуулах нь төрийн үүрэг. Харин тэрхүү хуулиар баталгаажуулсан эрхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараа ч найдвартай эдлүүлэх нь шүүхийн үүрэг юм. Хууль тогтоогч давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хянах эрхийг олгосон нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой

тухай хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай”
https://legalinfo.mn/mn/detail/640?fbclid=IwAR2Ch748_AXkgQ0tS3C-YxZVczRjez797e2dmOfTgHwmmZNUoVezsj_kjzj

¹ УДШ-ийн 2007.11.15-ны өдрийн “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай” зөвлөмж, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231250921371>

холбоотой гомдлыг аль болох хугацаа алдалгүйгээр түргэн шуурхай шийдвэрлэх зорилготой.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай зохицуулалт нь процессын бие даасан хуулиуд батлагдах үед байсан тул шинэ зохицуулалт гэж үзэх боломжгүй. Гэвч онолын ойлголт, хууль хэрэглээний хувьд тогтворжоогүй, эргэлзээ бүхий зохицуулалт байсаар байна. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хянан үзэх асуудал нь хэргийн оролцогчдын хувьд давж заалдах гомдол гаргах эрхийн нэгэн адил ач холбогдолтой зохицуулалт юм. Тиймээс давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй, энэ үйл баримтын талаар шүүхэд дахин маргаан үүсэх боломжгүй байдлаараа шүүхийн эцсийн шийдвэртэй үр дагаврын хувьд ижил шинжтэй шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт хамааруулах шаардлагатай.

Иймд ЗХШХШТХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэгт, мөн хуулийн 66-68 дугаар зүйлд заасан хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг хамааруулах нь зүйтэй тул энэ талаар Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4-д зааснаар Улсын дээд шүүхээс ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг хэрхэн хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй болов уу гэж хувь судлаачийн зүгээс үзэж байна.